


**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР**

Огноо: 2021 оны 01 дүгээр сарын 11-ны өдөр



**БИЧИГ ХЭРГИЙН БАРАА НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН  
ШАЛГАРУУЛАХ ТЕНДРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер  
Шалгаруулалт /  
Гэрээний нэр:  
Тендер  
шалгаруулалт/  
гэрээний дугаар:

Бичиг хэргийн бараа нийлүүлэх нийлүүлэгчийг  
сонгон шалгаруулах тендрийн баримт бичиг

**БХР-2021 ЦГ-02**

2021 ОН

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**[Баянхонгор аймаг дахь цагдаагийн газар]** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **[Бичиг хэргийн бараа материал]**-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулинд нийцүүлэн тендерийн баримт бичигт тодорхойлсон журам болон Харьцуулалтын аргаар /хялбаршуулсан цахим хэлбэрээр/ нийлүүлэгчийг сонгоно.

Тендерийг цахим хэлбэрээр зохион байгуулж байгаа тул үнийн саналыг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлнэ. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 (Тавин мянган) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийг **[2021 оны 01 дүгээр сарын 20-ны 10 цаг 00 минут]**-аас өмнө төрийн худалдан авах цахим системд илгээсэн байх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **[2021 оны 01 дүгээр сарын 20]-ны өдрийн, [10цаг 10 минут]** –д нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Эрхгүй**

Дотоодны давуу эрх тооцох эсэх: **Тооцно**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Баянхонгор аймаг, Баянхонгор сум Дуурсах 3-р баг Цагдаагийн газар 2  
давхар 200 тоот өрөө, Утас: 70194108

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
  - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
3. Тендерийн иж бүрдэл
  - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. Тогтмол үнэ
  - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд
  - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
  - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
  - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТӨӨЗ-НЫ ХОЛБОГДОХ ЗААЛТ	ТӨӨЗ 1.1
Шалгуур үзүүлэлт	<p>Тендер оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Энэхүү тендерийн бичиг баримтад тусгагдсан жишиг маягтын дагуу оролцох багц тус бүрээр үнийн саналыг гаргаж баталгаажуулан ирүүлэх</li> <li>2. Үлсын бүртгэлийн гэрчилгээг нотарматаар баталгаажуулсан хуулбар</li> <li>3. Тендер оролцогчийг төлөөлж гарын үсэг эдтгээдийн итгэмжлэлийг маягтын дагуу гаргаж ирүүлнэ.</li> <li>4. Шүүхийн байгууллагаас сүүлийн 3 жилтэй холбогдох тодорхойлолт ирүүлэх.</li> <li>5. Шүүхээр шийдвэрлэгдсэн өртэй эсэх талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт ирүүлэх. /Хугацаа тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байх/</li> <li>6. Харилцагч Татварын байгууллагаас өр төлбөргүй тухай лавлагаа тодорхойлолтыг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Татварын ерөнхий газрын татвар төлөгчдийн мэдээллийн сан e-balance-аас тендер оролцогчдын татвар төлөлт, санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, шаардлагатай мэдээллийг шалгана. /Тендер нээсэн өдрийн байдлаар өргүй байх/</li> <li>7. Харилцагч Нийгмийн даатгалын байгууллагаас өр төлбөргүй тухай лавлагаа тодорхойлолт ирүүлэх. /Тендер нээсэн өдрийн байдлаар өргүй байх/</li> <li>8. Үрт хугацааны болон хугацаа хэтэрсэн зээлтэй эсэх талаар Монголбанкны тодорхойлолт эсхүл харилцагч бүх банкнаас ирүүлэх</li> <li>9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдаана авах тухай хуулийн 14-дүгээр зүйлийн 14.1-д заасна нөхцөл байхгүйг бичгээр ирүүлэх. /Тендер оролцогч нь үзлэгээний хорооны гишүүдэд нөлөөлөх, нөлөөлөхийг оролдсон нь баримтаар нотлогдвол тендерээс татгалзана./</li> <li>10. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл: Сүүлийн 1 жил буюу 2020 онд улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн ижил төстэй барааны жагсаалт гаргаж гэрээ, актын хамт ирүүлнэ. /ижил төстэй ажилд бараа нийлүүлж байсан туршлагыг тооцно/</li> <li>11. Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Татварын ерөнхий газрын татвар төлөгчдийн e-balance-аас тендер оролцогчдын татвар төлөлт, санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, шаардлагатай мэдээллийг шалгана.</li> <li>12. Гүйцэтгээр ажилласан байх жилийн тоо: Сүүлийн 1 жил /2020/ гүйцэтгээр шалгаруулалтаар гүйцэтгэх гэрээтэй ижил төстэй бараа гэрээгээр заавал гүйцэтгэсэн байх бөгөөд 2020 онд батлагдсан төсөвт өртгийн 60 хувиас багагүй болон түүнээс дээш төрөгийн барааг нийлүүлсэн байна.</li> <li>13. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил /2018, 2019/ оны борлуулалтын орлогын нийт мөнгөн дүнгийн дундаж нь санал болгож үнийн дүнгийн 60 хувиас багагүй байх байна.</li> <li>14. Тургэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн</li> </ol>

ТӨЭЗ 2.3	<p>Төндөрт оролцогч төндөрийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь файл үүсгэн ирүүлнэ. Тус файлын</p>
ТӨЭЗ 2.1	<p>Төндөрийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үнд:</p> <p>Байшин, гудамжны нэр: Дүүрсах 3-р баг Баянхонгор аймags дахь цагдаагийн газар</p> <p>Даяхар болон ерөөний дугаар: 2 дахар 200 тоот өрөө</p> <p>Аймаг, хот: Баянхонгор аймаг</p> <p>Шүүдэнгийн дугаар:</p> <p>Улс: Монгол Улс</p> <p>Төндөрийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: 2021 оны 01 дүгээр сарын 20-ний өдөр</p> <p>Цас: 10 цаг 10 минутаас</p>
ТӨЭЗ 2.1	<p>Төндөр хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Баянхонгор сум Дүүрсах 3 дугаар баг Баянхонгор аймаг дахь цагдаагийн газар 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр 10 цаг 00 минутанд төрийн худалдан авах цахим системд шгээгч үү.</p>
	<p>Хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгийн 60%-иас багатай байх.</p> <p>Түргэн хөрвөх чатвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлийн нийт дүнг тараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэсээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр нь тодорхойлно. - Байгууллагын дансны үлдэгдэл харилцагч банкны тодорхойлолтоор /Хувь хүний нэр тээрх буюу захирлын нэр тээрх дансны үлдэгдлийг тооцохгүй/ - Арлжааны банкны эзэлийн тодорхойлолтыг тус тус тооцно /Банкны сүтгэн үзэж эзэл олгох боломжтой эсхүл шаардлагатай баримт материалыг үндэслэн гэх тодорхойлолтыг үнэлгээнд харгалзахгүй сүтгэлгэн тодорхойлолт байх</p> <p>15. Тухайн бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, машин механизм, бараа нийлүүлэх хугацаанд /өөрийн, түрээслэх, хөдсөн авах г.м/ бэлэн байлгах шаардлагатай. Тоног төхөөрөмжийн нотлох баримт ирүүлэх.</p> <p>16. Нийлүүлэлтийн баталгаажуулсан график ирүүлэх</p> <p>17. Төндөрт оролцогч нь үг төндөрт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан техникийн тодорхойлолтын даруу чанарын өндөр түвшинд тухайн барааг нийлүүлэн хүлээлгэн өгөх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ.</p> <p>18. Төндөрт шалгарсан тохиолдолд нийлүүлэгч нь өөрийн зардлаар барааг хүлээн авах газарт хүлээлгэн өгөхөө албан бичгээр гаргаж ирүүлнэ.</p> <p>19. Тухайн төндөрт оролцогч, түүний нийлүүлэх бараа нь захиалгачийн шаардсан техникийн тодорхойлолт болон стандартад нийцэж буйг нотлох баримт, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байр, агуулах гэх мэт барааг бүтэн жилийн хугацаанд тасралтгүй, гэрээний даруу нийлүүлэх боломжтойг нотлох баримт фото зураг зэрэг холбогдох мэдээллийн хамт тусгайлан бэлтгэж ирүүлэх.</p> <p>20. Тухайн төндөрийн баримт бичгийн талаарх тодруулгын харилт төрийн худалдан авах ажиллагааны <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим системд байрлуулах тул төндөрт оролцохыг сонирхогч этгээдүүдэд нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно. Иймд төндөрт оролцохыг сонирхогч этгээдүүдэд зөвлөж байна.</p>

	эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна.
<b>ТӨӨЗ 6.2</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>2 багц</b>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт: "А" багц

Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдах принтер, өнгөт хэвлэгч, бичгийн цаас нийлүүлэх.

№	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Тайлбар
1	Samsung ML-2165	Ширхэг	10		Олон улсын болон Монгол улсын дүрэм журам, стандартанд нийцсэн байх.  Зориулалтын сав баглаа боодолтой байх.
2	Samsung ML-1670	Ширхэг	10		
3	Samsung ML-3405	Ширхэг	10		
4	Samsung ML-1640	Ширхэг	10		
5	Samsung ML-3400	Ширхэг	10		
6	Samsung ML-1610	Ширхэг	10		
7	Samsung ML-2070	Ширхэг	10		
8	Samsung ML-2900	Ширхэг	10		
9	Epson-L850	Ширхэг	10		
10	HP-125a	Ширхэг	5		
11	HP-1132	Ширхэг	5		
12	Epson-1190	Ширхэг	5		
13	HP-M12A	Ширхэг	5		
14	Samsung ML-2165	Ширхэг	20		
15	Samsung ML-1670	Ширхэг	20		
16	Samsung ML-3405	Ширхэг	5		
17	Samsung ML-1640	Ширхэг	1		
18	Samsung ML-3200	Ширхэг	5		
19	Samsung ML-1610	Ширхэг	10		
20	Samsung ML-2070	Ширхэг	5		
21	HP-125a	Ширхэг	10		
22	HP-1132	Ширхэг	5		
23	HP-M12A	Ширхэг	10		
27	Бичгийн цаас	Боодол	732		Олон улсын болон Монгол улсын дүрэм журам, стандартанд нийцсэн байх, 80 граммтай
<b>Нийт өртөг</b>					<b>11.000.000</b>



2. Барааны тодорхойлолт: “Б” Багц Баянхонгор цагдаагийн газрын албан хэрэгцээнд зориулж, шаардагдах бичиг хэргийн бараа материал нийлүүлэх.

№	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Тайлбар
1	Өнгөт цаас /зузаан/	Боодол	10		Олон улсын болон Монгол улсын дүрэм журам, стандартанд нийцсэн байх.  Орос, Солонгос, Япон улсад үйлдвэрлэсэн автомашины сэлбэг
2	Өнгөт цаас /нимгэн/	Боодол	10		
3	Корона хавтас	Ширхэг	150		
4	Нүхтэй уут	Боодол	10		
5	Скоч том	Ширхэг	50		
6	Цаасны хайч	Ширхэг	30		
7	Цаасны цавуу	Ширхэг	70		
8	Архивын утас	Ширхэг	20		
9	Цаасны хутга	Ширхэг	30		
10	Штринк	Ширхэг	50		
11	Үдээсний машин	Ширхэг	30		
12	Үдээсний запас	Ширхэг	100		
13	Үдээс авагч	Ширхэг	50		
14	Харандаа	Ширхэг	100		Хайрцаг сав баглаа боодолтой байх
15	Цаасны хавчаар	Ширхэг	300		
16	Үзгэн бал	Ширхэг	200		
17	Тосон бал	Ширхэг	250		
18	Хавтас	Ширхэг	50		
19	Баллуур	Ширхэг	30		
20	Шугам 30 см	Ширхэг	30		
21	Шугам 1 метр	Ширхэг	5		
22	Фото цаас А 4	Боодол	20		
23	Фото цаас А 3	Боодол	10		
<b>Нийт өртөг</b>					<b>8.494.000</b>

**Баглаа, боодол тээвэрлэлт:** Бүтээгдэхүүн нь зориулалтын сав баглаа боодолтой байх ба бүтээгдэхүүний нэр үйлдвэрлэгчийн нэр хаягийг тодорхой бичсэн хаяг шошготой байна.

**Бараа хүргэх газар:** Баянхонгор аймаг дахь цагдаагийн газарт

**Бараа нийлүүлэлтийн хуваарь:** Улирал тутам

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <i>[тоо]</i> жил байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <i>[ГТН-д заасан тоо]</i> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
  - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
  - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
  - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
  - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[тоо]**<sup>1</sup> хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>2</sup> 9.1. Алданги оногдуулах хувь: **[тоо]**
- Алдангийн нийт дүн: **[тоо]**

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

<sup>2</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

НИЙЛҮҮЛЭГЧ

ЗАХИАЛАГЧ

\_\_\_\_\_ (Тамга, тэмдэг)  
 \_\_\_\_\_ (Гарын үсэг)  
 \_\_\_\_\_ (Албан тушаал)

\_\_\_\_\_ (Тамга, тэмдэг)  
 \_\_\_\_\_ (Гарын үсэг)  
 \_\_\_\_\_ (Албан тушаал)

**[Төндөр талгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Төндөр талгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймгад

Нэг талаас **[захалагчийн нэр]** (цаашид "захалагч" гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид "нийлүүлэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид "бараа" гэх) **[гэрээний үнэ]** гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн **болон үсгээр** (цаашид "гэрээний үнэ" гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн төндөрийг үүрэг хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төргөийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төргөийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төргөийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ барааг \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

- Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- Бусад шаардлагатай баримт бичиг;
- Үнийн санал;
- Гэрээний тусгай нөхцөл;
- Гэрээний ерөнхий нөхцөл;
- Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
- Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]